



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/74/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг:jenisbekh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>Уужим Алтай Аудит ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	НОГООННУУР СУМЫН ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Т.БАХЫТГҮЛ ТАНАА
<p>᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № ᠒15 танай _____-ны № _____-т</p>	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>	
Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага	
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p>	

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,893,196.01</u>	<u>30,974,676.02</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,959.51	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	27,959.51	-
3121	Төгрөг	27,959.51	-
31213	Арилжааны банк дахь харилцах	27,959.51	-
33	АВЛАГА	-	1,060.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,060.52
35	БАРАА МАТЕРИАЛ	27,865,236.50	30,973,615.50
354	Хангамжийн материал	27,865,236.50	30,973,615.50
35420	Аж ахуйн материал	2,320,000.00	1,209,100.00
35440	Түлш, шатах тослох материал	1,350,000.00	2,312,534.00
35460	Хүнсний материал	3,470,536.00	6,591,281.00
35470	Бусад хангамжийн материал	20,724,700.50	20,860,700.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>187,643,147.96</u>	<u>176,420,621.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	187,643,147.96	176,420,621.07
392	Биет хөрөнгө	178,733,147.96	167,510,621.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	187,143,596.00	190,824,360.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,784,775.69)	(46,229,052.43)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,424,700.00	27,178,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,451,639.88)	(17,123,959.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,343,040.54	14,062,269.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,528,029.58)	(9,424,920.96)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	58,926,652.00	52,481,214.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	(47,340,395.43)	(44,257,889.44)
393	Биет бус хөрөнгө	8,910,000.00	8,910,000.00
39301	Програм хангамж	-	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө	8,910,000.00	8,910,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>215,536,343.97</u>	<u>207,395,297.09</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9,251,770.00</u>	<u>2,152,453.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,251,770.00	2,152,453.00
413	Өглөг	9,251,770.00	2,152,453.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8,425,622.00	2,103,853.00
4136	Бусад өглөг	826,148.00	48,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	826,148.00	48,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>206,284,573.97</u>	<u>205,242,844.09</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	206,284,573.97	205,242,844.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,798,700.00	82,798,700.00
51101	Өмч: - төрийн	82,798,700.00	82,798,700.00
512	Хуримтлагдсан үр дүн	(41,169,385.59)	(42,211,115.47)
51210	Өмнөх үеийн үр дүн	(41,169,385.59)	(41,169,385.59)

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,041,729.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,655,259.56	164,655,259.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	215,536,343.97	207,395,297.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	432,759,052.51	406,651,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,540,396.51	5,866,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,540,396.51	5,866,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,540,396.51	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,956.51	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,532,440.00	-
120009	Бусад орлого	-	5,866,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,218,656.00	400,785,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	410,781,750.00	388,044,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	10,126,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	410,781,750.00	377,917,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,664,800.00	12,535,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,664,800.00	12,535,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,772,106.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,772,106.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	454,482,366.81	403,847,525.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,482,366.81	403,847,525.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,710,260.81	403,847,525.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,628,678.00	303,542,800.48
210101	Үндсэн цалин	297,899,609.00	270,758,200.48
210104	Урамшуулал	20,646,422.00	21,814,144.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,082,647.00	10,970,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,454,418.00	44,207,500.00
210201	Тэтгэврийн даатгал	41,454,418.00	31,936,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,067,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,454,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	613,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,135,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,487,794.00	10,863,266.00
210301	Гэрэл, цахилгаан	1,736,800.00	1,336,800.00
210302	Түлш, халаалт	9,750,994.00	9,526,466.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,042,154.00	2,744,620.00
210401	Бичиг хэрэг	1,482,588.00	1,011,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,353,230.00	1,051,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	248,900.00	681,820.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	-

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,882,136.00	-
2105	Нормативт зардал	32,234,250.00	16,390,357.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	375,440.00	954,250.00
210502	Хоол, хүнс	31,525,910.00	15,436,107.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	-
210604	Урсгал засвар	210,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	125,600.00	138,000.00
210702	Дотоод албан томилолт	125,600.00	138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,000.00	250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,329,366.81	25,710,982.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,321,759.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,100.00	286,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,254,266.81	18,103,222.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,772,106.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,772,106.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,772,106.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21,723,314.30)	2,803,874.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,845,604.25
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,845,604.25
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,845,604.25)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(21,723,314.30)	(1,041,729.88)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	73,888,700.00	135,943,372.00	36,610,297.40	246,442,369.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	73,888,700.00	135,943,372.00	36,610,297.40	246,442,369.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	10,930,580.00	0.00	33,642,214.92	-22,711,634.92
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	84,819,280.00	135,943,372.00	2,968,082.48	223,730,734.48
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	84,819,280.00	135,943,372.00	2,968,082.48	223,730,734.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	84,819,280.00	135,943,372.00	2,968,082.48	223,730,734.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,041,729.88	-1,041,729.88
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	84,819,280.00	135,943,372.00	1,926,352.60	222,689,004.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>429,226,612.51</u>	<u>396,525,100.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,956.51	5,866,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,956.51	5,866,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,956.51	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,956.51	
120009	Бусад орлого		5,866,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,218,656.00	390,658,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	410,781,750.00	377,917,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	410,781,750.00	377,917,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
1330	Төсвийн захирагчдаас	15,664,800.00	12,535,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,664,800.00	12,535,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,772,106.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,772,106.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>422,279,796.00</u>	<u>395,953,059.51</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	422,279,796.00	395,953,059.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,507,690.00	395,953,059.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	328,776,300.00	308,861,700.00
210101	Үндсэн цалин	290,949,200.00	276,077,100.00
210104	Урамшуулал	20,776,400.00	21,814,144.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,050,700.00	10,970,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,455,300.00	44,207,500.00
210201	Тэтгэврийн даатгал	29,114,400.00	31,936,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,335,100.00	3,067,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,668,400.00	2,454,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	667,000.00	613,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,670,400.00	6,135,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,380,110.00	12,325,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,336,800.00	1,336,800.00
210302	Түлш, халаалт	12,397,910.00	10,489,000.00
210303	Цэвэр, бохир ус	645,400.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,913,200.00	3,177,800.00
210401	Бичиг хэрэг	627,800.00	476,700.00
210402	Тээвэр, шатахуун	999,000.00	855,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,500.00	460,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	63,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	798,600.00	1,322,800.00

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	зүйлс		
2105	Нормативт зардал	29,006,230.00	23,971,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,300.00	467,000.00
210502	Хоол, хүнс	28,145,930.00	22,960,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	651,000.00	544,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	210,000.00
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00
2107	Томилолт, зочны зардал	604,200.00	334,800.00
210702	Дотоод албан томилолт	604,200.00	334,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	449,100.00	375,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,100.00	125,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	198,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	713,250.00	2,488,459.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,232,959.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	713,250.00	1,255,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,772,106.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,772,106.00	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,772,106.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,946,816.51</u>	<u>572,040.49</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,938,860.00	600,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,938,860.00	600,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,938,860.00	600,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,938,860.00	600,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(6,938,860.00)</u>	<u>(600,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,956.51	(27,959.51)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,003.00	27,959.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,959.51	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27,959.51
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	390,453,700.00	390,481,659.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,453,700.00	390,481,659.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,453,700.00	390,481,659.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,786,500.00	306,786,500.00
210101	Үндсэн цалин	274,001,900.00	274,001,900.00
210104	Урамшуулал	20,491,500.00	21,814,144.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,293,100.00	10,970,456.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,416,300.00	41,416,300.00
210201	Тэтгэврийн даатгал	29,144,800.00	29,144,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,067,900.00	3,067,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,454,300.00	2,454,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	613,600.00	613,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,135,700.00	6,135,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,325,800.00	12,325,800.00
210301	Гэрэл, цахилгаан	1,336,800.00	1,336,800.00
210302	Түлш, халаалт	10,489,000.00	10,489,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,777,800.00	3,777,800.00
210401	Бичиг хэрэг	654,800.00	625,600.00
210402	Тээвэр, шатахуун	855,000.00	855,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	460,000.00	460,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	63,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,732,700.00	1,773,900.00
2105	Нормативт зардал	23,971,400.00	23,971,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	467,000.00	467,000.00
210502	Хоол, хүнс	22,960,300.00	22,960,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	544,100.00	544,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	210,000.00	210,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00
2107	Томилолт, зочны зардал	334,800.00	334,800.00

210702	Дотоод албан томилолт	334,800.00	334,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	375,600.00	375,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,600.00	125,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,255,500.00	1,283,459.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		27,959.51
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,255,500.00	1,255,500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	390,453,700.00	390,453,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	377,917,900.00	377,917,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	377,917,900.00	377,917,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,535,800.00	12,535,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	12,535,800.00	12,535,800.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	11.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	6,071,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	6,071,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	6,071,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	2,075,200.00
210101	Үндсэн цалин		2,075,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	2,791,200.00
210201	Тэтгэврийн даатгал		2,791,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	200,000.00
210401	Бичиг хэрэг		200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,005,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,005,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	6,071,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	6,071,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,866,400.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, аудитын менежер Х.Женисбек нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд Ногооннуур сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн өмнөх оны санхүүгийн баримтуудад шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн

дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 451.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.1 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28.0	0.0	-28.0
Авлага	0.0	1.1	1.1
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	27 865.2	30 973.6	3 108.4
Үндсэн хөрөнгө	187 643.1	176 420.6	-11 222.5
Нийт хөрөнгө	215 536.3	207 395.3	-8 141.0
Өр төлбөр	9 251.8	2 152.5	-7 099.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	206 284.6	205 242.8	-1 041.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	215 536.3	207 395.3	-8 141.0

Урьдчилгааны данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхнээс 0.02 сая төгрөгөөр буурсан байна. Оны эцэст мөнгөн хөрөнгөний үлдэгдэлгүй гарсан.

Авлага дансны үлдэгдэл 1.1 мянган төгрөг болж нэмэгдсэн байна. Энэ нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31.0 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр өссөн нь хүнсний материалын дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн хөрөнгөөр 37.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 34.6 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 176.4 сая төгрөг болж 11.2 сая төгрөгөөр буурсан нь 0.6 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 18.1 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ. Тайлант хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоолоор 10.7 сая, Ногооннуур сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор 7.5 сая төгрөгийн, нийт 18.2 үндсэн хөрөнгийн актлах зөвшөөрөл өгсөн ба тайлант хугацаанд 16.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, тухайн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг зөрүү 3.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгө худалдсаны гарз дансанд тусгасан. Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн бууралтад акталсан хөрөнгийн дүн нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 1.0 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 406.6 сая төгрөг болж өмнөх оноос 26.1 сая төгрөгөөр буюу 6.0 хувиар буурсан дүнтэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 403.8 сая төгрөг болж өмнөх оноос 50.6 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 405.5 сая төгрөг, тодотгосон төсөв 390.4 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөсөө 15.0 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 17.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлийг 2.3 сая, хангамж бараа материалыг зардлыг 1.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нормативт зардлыг 32.5 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс хэмнэлттэй гарах боловч хүнсний материалын үлдэгдлийг нөөцлөн хадгалсантай холбоотой хэмнэгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд 390.4 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 377.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 12.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 377.9 сая, орон нутгийн төсвөөс 12.5 сая, нийт 390.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 390.4 сая төгрөгийг зарцуулж, төсөвт буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байхгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 390.4 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Нийт төсвийн 70.6 хувийг цалин, 9.5 хувийг НДШ-ийн зардал, 6.4 хувийг тогтмол зардал, 0.8 хувийг хангамж бараа материалын зардал, 8.8 хувийг норматив зардал, 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.6 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас 0.2 сая төгрөгийн санхүүжилт, өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актын дүн болох 5.9 сая төгрөгийн орлогыг хүлээн авч, уг санхүүжилтийг бичиг хэрэг, цалин, нийгмийн даатгал болон бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбоотой онцолсон асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 116 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 33 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17.3 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ✓ Өр төлбөр үүсгэсэн талаарх 2.1 сая төгрөгийн 1 шийдвэрийг оруулаагүй байна.
- ✓ 5 сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад орлогын 26 мэдээллийн 23-ыг хугацаандаа оруулж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Хугацаандаа мэдээлсэн боловч тайлант оны эхний бүх саруудад 371.5 сая төгрөгийн санхүүжилтийн дүнг хоосон мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр 390.9 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 6.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, авлага, өглөгийн бүртгэл тооцоо, шилэн данстай холбоотой 10.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна. Биелэлтийг давтан шалгаж үзэхэд авлагатай холбоотой зөрчлийг арилгасан боловч оны эцэст өглөгийг бүрэн барагдуулаагүй, 1.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар тус Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, нярвын бараа материалын тайлангийн бүрдүүлэлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалын зарцуулалтад хяналт тавих, эд хөрөнгийн тооллогын тооцоо бодолтод анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 1.8 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 4.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ногооннуур сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлээр 390.4 сая төгрөгийг зарцуулсан ба 381.6 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал бөгөөд үлдсэн 8.8 сая төгрөг нь тэвчиж болох зардал байна. Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад тэвчиж болох 8.8 сая төгрөгийн зардлыг 10 хувь буюу 0.8 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй байна.

Оны эцэст 2.1 сая төгрөгийн өглөгтэй гарч он дамжсан өр, төлбөрийг бүрэн барагдуулаагүй, өмнөх оны аудитаар тогтоосон 1.1 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлын төсвөөс зарцуулсан 0.3 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 0.8 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдлийг нярвын бараа материалын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 0.7 сая төгрөгийн зөрүүтэй, бараа материалын тайлангийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн, зардлын нотлох баримтууд хангалтгүй байх зэрэг нийт 1.8 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.1.1, 20.1.3, 20.1.4, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар

баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	2	5.9					1	4.1	1	1.8